



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Зээлийн дугаар ба нэр: Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төсөл

Гэрээний дугаар ба нэр: CW-07 дугаартай Увс аймгийн Улаангом суманд 120м2 өвлийн хүлэмж барьж, хүлээлгэн өгөх (Түлхүүр гардуулах нөхцөлтэй)

Тендер хүлээн авах эцсийн огноо ба цаг: 2020 оны 8-р сарын 31-ний өдрийн 11 цаг 00 минут

1. Хүнс Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-нд хэрэгжиж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” 9192-MON төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом суманд 120м2 өвлийн хүлэмж барьж, хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэхэд үнийн саналаа ирүүлэхийг хүсэж байна.

2. Тендерт оролцогч нь дор дурьдсан бичиг баримтуудыг үнийн саналын хамт ирүүлнэ. Үүнд:

1. Үнийн санал ирүүлэх маягт
2. Санхүүжүүлэх үйл ажиллагааны хуваарь
3. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
4. Барилгын тусгай зөвшөөрөл
 - БА 2.1 /2.1.2/ Цугтамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
 - БА 6.2 /2.2.1/: Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, хөргөх байгууламж тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт (өргүй, эх хувь)
6. Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа (эх хувь)
7. Нийгмийн даатгалын лавлагаа (өргүй, эх хувь)
8. Татварын цахим тодорхойлолт (өргүй, эх хувь)
9. Өвлийн хүлэмжний загвар зураг төслийг, төсөвийн хамт ирүүлнэ.

3. Тендерт оролцохыг сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Байгууллага: Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төсөл, Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Сайн констракшны байр, 3 давхар, 304 тоот

Харилцах албан тушаалтан: М.Ганпүрэв, Төслийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн

Утас: +976 7012-9192, +976 9929 9996

Цахим шуудан: ganpurev1981@gmail.com